

Тамирчин сонгон шалгаруулах журам

Тавигдах нийтлэг шалгуур үзүүлэлтүүд Тамирчид дараах шаардлагыг хангасан байна: Монголын улсын иргэн байна. Сонсгол дор хаяж 55 дб-ээр алдагдсан байх ёстой. Монголын Диф Спортын Холбооны (МДСХ) болон тухайн спортын холбооны гишүүн бөгөөд гишүүний татвараа төлсөн байна. МДСХ-ны баталсан Ес Зүйн дүрэмтэй танилцаж, дагаж мөрдөхөө батлан гарын үсгээ зурна. МДСХ, ОУДСХ болон Дэлхийн Сэргээшийн Эсрэг Агентлагийн дүрэм журмын дагуу сэргээшийн шинжилгээнд ямар ч тайлбаргүй хамрагдана. Сонгон шалгаруулалтаар гарч ирснээс хойш тасралтгүй бэлтгэл хийх үүрэг хүлээнэ. Монголын багийн албаны хүмүүст бэлтгэлийн явц, тэмцээн уралдаанд оролцсон үр дүнгээ мэдээлэх үүрэгтэй. Тамирчин хүний эрхэм сайн чанаруудыг харуулж бусдад үлгэр дууриалтай байна. Монголын багийн бүрэлдэхүүнд орох материалууд, үүнд Монгол улсын гадаад паспортын хуулбар, эргэж үл төлөгдөх нөхцөлөөр Монголын багт орох өргөдлийн хураамж 100,000 төгрөгийг шилэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төлнө. Олон Улсын Диф Спортын Хорооны (ОУДСХ) сонсголын бичлэг хийх маягтыг татаж аваад шилэгдсэнээс хойш 30 хоногийн дотор бичлэг хийлгэж МДСХ-д өгнө. Тамирчныг сонгохдоо тухайн спортын төрөл онцлогт нь тааруулж холбоодын зүгээс тусгай шалгуур гаргаж батлуулна. Үүнд шалгуур үзүүлэлтийг тайлбарлаж, сорил тэмцээн явуулах хугацааг тодорхой заах, улмаар сонгон шалгаруулсан тамирчдаа МДСХ-ны удирдах зөвлөлд оруулж батлуулах зэргийг тусгана. Монголын багийн бүрэлдэхүүнд орсон боловч бэртэл гэмтэл, өвчтэй зэрэг шалтгааны улмаас Дифлимпэд оролцох боломжгүй болсон тохиолдолд түүний дараагийн хүнийг нөхөн оруулна. Сонгон шалгаруулах комисс.Тамирчид сонгон шалгаруулалт шударга бус болсон гэж үзвэл гомдлоо гаргах эрхтэй.